

Дэлгэрцогт сумын Цэргийн насны залуучуудын дунд зохион байгуулсан сургалт, тэмцээн уралдааны тайлан

2018 оны 10 сарын 04-ны өдөр Дэлгэрцогт сумын 1992-2000 оны залуучуудын дунд Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн тухай хууль, Дайчилгааны тухай хуулиар ЗДТГ-ын дарга С.Нарантунгалаг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хэсгийн төлөөлөгч Г.Эрдэнэбат нар сургалт зохион байгууллаа. Бага боловсролтой залууст 9-н жилийн сургуулийн бага ангийн багш Л.Байгальмаа Монгол хэл, Математикийн сургалтыг зохион байгууллаа. Мөн суурь боловсролтой залууст 9-н жилийн сургуулийн Англи хэлний багш Б.Поня англи хэлний анхан болон дунд шатны сургалтыг зохион байгууллаа.

Сургалтын дараагаар цэргийн насны залуучуудын дунд “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнийг зохион явууллаа.

Сагсан бөмбөгийн тэмцээнд нийт 7 баг орсноос Б.Довуучий ахлагчтай баг 1-р байр, Б.Энхбаяр ахлагчтай баг 2-р байр, Ц.Пүрэвсүрэн ахлагчтай баг 3-р байранд тус тус шалгарлаа.



